

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 01

Дархан-Уул аймаг

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн  
дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14 дэх заалт, Компанийн дүрмийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 03 сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Дархан нэхий ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

**Хоёр.** Монгол улсын Компанийн тухай хуулийн 96.4-д заасныг удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн гүйцэтгэх удирдлагын багаас танилцуулсан тайланг “Хангалттай” гэж үзсүгэй.



Э. БАТСАЙХАН

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 дүгээр сарын 05-ны өдөр

дугаар 02

Дархан-Уул аймаг

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, ТУЗ-ийн зардлын төсвийг  
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62.1.7, 62.1.13 болон 77 дугаар зүйлийн холбогдох заалтууд болон тус компанийн дүрмийн 7.22, 7.23, 7.25-д заасныг тус тус удирдлага болгон 2022 оны 03 сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг:** Дархан нэхий ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.

**Хоёр:** Дархан нэхий ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр доорхи нэр дэвшигчдийг тус тус 1 жилийн хугацаатай сонгосугай.

Хараат гишүүд:

1. Эрдэнэдалайн Батсайхан
2. Равжаагийн Сүмбэнхүү
3. Батсайханы Чинчулуун
4. Сүмбэнхүүгийн Хулан
5. Баасангийн Гэрэлмаа
6. Батсайханы Мягмар-Өлзий

Хараат бус гишүүд:

1. Далхжавын Батжаргал
2. Хумбагайн Золжаргал
3. Баатарын Бурмаа

**Гурав:** Дархан нэхий ХК-ийн 2022 оны ТУЗ-ийн зардлын нийт 94.0 сая төгрөгний төсвийг хавсралтаар баталсугай.



Э. БАТСАЙХАН

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 03

Дархан-Уул аймаг

ХЭХурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлыг  
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн холбогдох заалтууд болон тус компанийн дүрмийн холбогдох заалтыг тус тус удирдлага болгон ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан доорх асуудлуудыг хэлэлцээд, 2022 оны 03 сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг:** “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн 2022 оны 02 сарын 11-ний өдрийн 02/01 тоот тогтоолыг баталсугай.

**Хоёр:** Аудитын байгууллагаар “ЦЭСБ-АУДИТ” ХХК –ийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай ДНХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны саналыг дэмжиж баталсугай.

**Гурав:** “Хөрөнгө татах асуудал”-ыг батлаж, зах зээлийн нөхцөл байдал, үнэ үнэлгээг нарийвчлан судалж, дахин тооцоолон хэрэгжүүлэх ажлыг нээлттэй үлдээх, мөн тодорхой нөхцөл байдлын боломжит хугацаанд шийдвэрлэн хэрэгжүүлэхийг Дархан нэхий ХК-ийн ТУЗ -д зөвшөөрсүгэй.



Э. БАТСАЙХАН